МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,108.831... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.10.06. Пүрэв. №178 (4548) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

МАН СОНГУУЛИЙГ ЛУЙВАРДАХ БОЛОМЖТОЙ ГЭВ

II нүүрт

СОНИРХУУЛАХАД

“АМЬД БАРБИ” МОНГОЛД ИРЛЭЭ

VIII нүүрт

чухал ХҮН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Г.БАТБААТАР: МАНАЙ ХАМТ ОЛОН АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ШИЛДЭГ СУРГУУЛЬ БОЛОХЫН ТӨЛӨӨ ХИЧЭЭН АЖИЛЛАЖ БАЙГАА

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV-V нүүрнээс

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Ц.ДАВААЦЭРЭН: “ЭРДЭНЭТ” ҮЙЛДВЭР УЛСЫН ТӨСӨВТ 20 БУС 134 ТЭРБУМ ТӨГРӨГ ТӨЛСӨН

Ж.ОТГОН

УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж хэдхэн хоногийн өмнө мэдээлэл хийж, “2016 оны эхний найман сарын байдлаар “Оюутолгой” ХХК нь 244.6 тэрбумын татвар төлсөн байхад “Эрдэнэт” үйлдвэр нь 20.3 тэрбум төгрөгийн татвар төлснийг харьцуулахад энэ үйлдвэр яаж ажиллаж байгаа нь харагдаж байна” гэх мэдээлэл хийсэн. Тэгвэл энэхүү асуудлаар тус үйлдвэрийн ерөнхий захирал Ц.Даваацэрэн, Хууль эрх зүйн газрын дарга Д.Цэрэнбадам зэрэг албаны хүмүүс мэдээлэл хийлээ. Хурлын эхэнд “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирал Ц.Даваацэрэн “Сүүлийн үед УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржийн мэдэгдэлтэй холбоотойгоор “Эрдэнэт” үйлдвэртэй холбоотой хариулт нэхсэн олон асуулт яригдаад байна. Тиймээс ч маш олон хэвлэл мэдээллийн байгууллагаас эдгээр асуултуудад “хариулт өгөөч” гэсэн хүсэлт ирсэн. Ингээд бид нэгдсэн байдлаар хэвлэлийн бага хурал хийхээр шийдсэн” гэдгээ дуулгалаа. Тэрбээр “Өнөөдөр “Эрдэнэт” үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Энэ оны эхний есөн сарын байдлаар өмнөө тавьсан үйлдвэрлэлийнхээ бүх төлөвлөгөө, даалгавруудыг 100 хувь биелүүлсэн. Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа доголдоогүй хэвийн сайн явагдаж байгаа. Бид одоогоор өвлийн бэлтгэл ажлаа хангаад явж байна” хэмээв.

Үргэлжлэл нь II нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## Гэр бүлийн хуулиа чангалаач

Э.ТУУЛ

Саяхан Дорнод аймгийн төв Хэрлэн суманд “захиалгат” гэх тодотголтой нэгэн хэрэг гарч, олны сэтгэлийг хирдхийлгэсэн. Тус сумын нэгдүгээр багт гарсан уг хэргийн улмаас долоон настай хүү амиа алдаж, иргэн Б гэгчийг дээрх хэрэгт холбогдолтой хэмээн үзэж, саатуулан шалгаж байгаа юм. Орон нутгийн эх сурвалжийн мэдээлснээр хүүгийн эцэг гэр бүлээс гадуурхи харилцаа үүсгэн, залуу бүсгүйтэй амраглаж байгаад түүнтэйгээ хамтран амьдрахаас татгалзсанаас үүдэн бүсгүй “амраг”-ийнхаа хүүгийн амийг хөнөөлгөх захиалга өгсөн гэлцэж буй. Гэр бүлээс гадуурхи харилцаанаас болоод бага насны хүүхэд хохирсон иймэрхүү тохиолдол өмнө нь тус аймагт гарч байсныг уншигч авхай та санаж байгаа биз ээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## “Хөшөө” Б.Батзоригийн газрын наймаа иргэдийн тэвчээрийн “утас”-ыг тасалж эхэллээ

Н.ПУНЦАГБОЛД

Эрх мэдэл, албан тушаалтай хүмүүс жирийн ард иргэдийг “номхон тэмээ ноолоход амар” гэдэг нүдээр харж, шүдээр хазаж, дээрэлхсээр ирсэн. Улсаа элгээр нь мөлхүүлж, ард түмнээ амаар нь шороо үмхүүлчихээд, хэдхэн төгрөгөөр хуураад яваад байж болно гэж боддог. Өнгөтэй өөдтэй бүхнийг хамж, газар хувьчлах нэрээр тоглосоор ирсэн. Одоо ч гэсэн тэгж л байгаа. Дарга нар л аль өнгөтэй өөдтэй гэсэн газрыг нь хамж авч зараад, иргэддээ болохоор уулын мухарт алга дарам газрыг сугалаагаар өгч байгаа шүү дээ газрыг. Тэгвэл өчигдөр иргэд зүгээр нэг дээрэлхүүлээд, өр рүүгээ өшиглүүлээд сууж байхгүй гэдгийг харуулсан үйл явдал боллоо. Тэр нь иргэн Б.Батдэлгэр гэгч эмэгтэй Төрийн ордны гадна “Газрын наймаачин луйварчин УИХ-ын гишүүн Б.Батзориг наймаг үхэлд хүргэв” бичиг хүзүүндээ зүүж, притка бариад зогссон явдал. Болохгүй бол амиа хорлоод ч болов хууль бус зүйлтэй, эрх мэдлээ хэтрүүлсэн дарга нартай тэмцэх гэж байна, ард түмэн. Энэ чинь одоо юу болж байна аа. Ходоодоор нь хуурч болно гэж бодсон иргэдийн чинь тархи нь ажиллаж байна. Ажиллах ажиллахдаа тэмцлийн хурц хэлбэрийг шууд сонгох гэж байна шүү дээ. Эрх баригчид аа, юу бодож сууна аа. Энэ хэргийн гол буруутан болох УИХ-ын гишүүн Б.Батзориг ингээд л албан тушаалын шат ахиад, эрх дарх нь нэмэгдээд л яваад байх уу. Нөгөө сайхан шударга ёс, иргэдээ бодно гээд байсан чинь яав. Шалгах ёстой газар нь шалгаад, шалтгаан байвал хариуцлага тооцож болдоггүй юм уу.

Үргэлжлэл нь III нүүрт




УИХ-ЫН ГИШҮҮН ТОЙРОГТОО...

## С.ЧИНЗОРИГ ГИШҮҮН ХИЙСЭН АЖЛАА ТАЙЛАГНАЖ, ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨСНӨӨ ТАНИЛЦУУЛАВ



Н.ЗАЯА

УИХ-ын сонгуулийн 21 дүгээр тойрог буюу Өвөрхангай аймгийн Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Баян-Өндөр, Сант, Баянгол, Хайрхандулаан, Нарийнтээл, Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Төгрөг гэсэн 12 сумын иргэдийн үнэмлэхүй олонхийн саналаар парламентад сонгогдсон С.Чинзориг гишүүн тойрогтоо ажиллаж, сонгогч олонтойгоо хийх уулзалтаа эх орны төв цэг Бүрд сумаас эхэлж нар зөв тойрон 3000 шахам хүнтэй нүүр тулан уулзлаа.

С.Чинзориг гишүүн уулзалтад ирсэн нутгийн олонд УИХ-ын анхдугаар чуулган болон олны анхаарлыг ихээр татсан ээлжит бус чуулганаар хэлэлцсэн асуудлуудын талаар дэлгэрэнгүй танилцуулахын хамт улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүндрэлээс гарах арга замын талаар ярилцаж, иргэдийн санаа бодлыг сонссон юм.

Тэрбээр хүмүүсийн дунд багагүй эргэлзээ төрүүлж бас ч үгүй бухимдуулаад амжсан цалин хасах, татвар нэмэх, хүүхдийн мөнгө, оюутны тэтгэмж, төрийн албан хаагчдад нэг удаа олгодог буцалтгүй тусламжийн талаар УИХ ямар шийдвэр гаргасныг танилцуулж, өөрийн байр суурийг илэрхийлсэн. Тухайлбал, эдийн засгийн хүндрэлээс гарахын тулд хэн нэгний цалин хөлсийг хасч танахаас илүүтэй үр ашиг муутай хөрөнгө оруулалтыг зогсоож, орлого олж болох өөр эх үүсвэрийг хайх, төр иргэддээ эрх тэгш шударга хандах зарчмын үүднээс төрийн албан хаагчдад олгодог нэг удаагийн тэтгэмжийг ажилласан жилтэй нь дүйцүүлэн олгодог байх ёстой гэсэн байр суурийг нэгдсэн чуулган, Байнгын хорооны хуралдаанд байнга илэрхийлж байсан. Татварын хувьд ч тэр хэд хэдэн зүйл дээр цөөнх болсон шалтгаанаа сонгогчдодоо тайлбарласан. Тэрбээр 150 ам метр талбайтай тансаг орон сууц эзэмшигчдээс татвар авч, архи, тамхины онцгой албан татварыг нэмэх нь зөв хэмээн үздэг гэхчилэн ярьж байлаа. Мөн өмнөх дөрвөн жилд эрх барьсан хүмүүсийн алдаатай бодлогын улмаас улсын сан хөмрөг нимгэрч, хөгшчүүдийн тэтгэвэр, хүүхдийн мөнгийг бүрэн бүтнээр нь олгоход хүндрэл үүсч, гаднаас хөрөнгө оруулалт татах, зээл тусламж хайхад амаргүй байгаа ч ард түмнийхээ амьдралыг сайжруулах бүхий л арга замыг эрэлхийлж ажиллах нь төр засгийн үүрэг гэдгийг тэрбээр онцолж байсан юм.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ХААН банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2268.00 | 2286.00 | ФУНТ | 2837.00 | 2945.00 |
| ЕВРО | 2514.00 | 2588.00 | РУБЛЬ | 37.90 | 38.10 |
| ИЕН | 21.82 | 22.47 | ЮАНЬ | 337.00 | 342.50 |

Худалдаа хөгжлийн банк

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2268.00 | 2287.00 | ФУНТ | 2852.00 | 2933.00 |
| ЕВРО | 2519.00 | 2590.00 | РУБЛЬ | 35.16 | 38.34 |
| ИЕН | 21.80 | 22.49 | ЮАНЬ | 337.50 | 342.40 |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Ц.ДАВААЦЭРЭН: “ЭРДЭНЭТ” ҮЙЛДВЭР УЛСЫН ТӨСӨВТ 20 БУС 134 ТЭРБУМ ТӨГРӨГ ТӨЛСӨН




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

## Ц.Нямдорж гишүүн худлаа мэдээлэл хийжээ

Энэ оны эхний найман сарын байдлаар “Оюутолгой” ХХК нь 244.6 тэрбумын татвар төлсөн байхад “Эрдэнэт” үйлдвэр нь 20.3 тэрбум төгрөгийн татвар төлсөн хэмээх мэдээлэл үнэн эсэхэд хариулт авлаа. “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирал Ц.Даваацэрэн “УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржийн хийсэн мэдэгдэл дотор “Эрдэнэт” үйлдвэр сүүлийн үед улсад төлдөг татвар, төлөөсөө бага төлөөд байна гэдэг агуулга бүхий мэдэгдэл гаргасан. Тиймээс ч энэ үйлдвэр яагаад улсын төсөвт төлөх ёстой татвараа бага өгөөд байна вэ гэсэн асуулт бидэнд маш их ирж байна. Тийм зүйл огт байхгүй. Энэ оны эхний найман сарын үзүүлэлтүүдийг бид албан ёсоор Сангийн яам, Татварын ерөнхий газарт хүргүүлсэн. Энэхүү үзүүлэлтээр “Эрдэнэт” үйлдвэр эхний найман сарын байдлаар улсын төсөвт 64 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байгаа. Харин орон нутгийн төсөвт 70 тэрбум гэхээр нийтдээ 134 тэрбум төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээд байна. УИХ-ын дэд дарга Ц.Нямдоржид яагаад “Оюутолгой” ХХК-иас 10 дахин бага буюу 20.3 тэрбум төгрөг төлсөн гэдэг мэдээлэл очсон юм гэхээр Татварын ерөнхий газраас өрөөсгөл, дутуу мэдээлэл өгсөнтэй холбоотой байх” хэмээн тайлбарлав.

## Сангийн яамны хүсэлтээр урьдчилж, төлбөр төлжээ

“Эрдэнэт” үйлдвэр жилийн жилд төр засгийн үйл ажиллагааг тодорхой хэмжээгээр дэмжиж урьдчилан төлбөр хийж ирсэн байна. Тухайлбал, 2013 онд л гэхэд 100 гаруй сая доллар, 2014 онд 70 сая доллар урьдчилан төлж байсан аж. Харин үүнээс хойш тооцоо хэрхэн хийгдсэн талаар “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирал Ц.Даваацэрэн “2015 оны төгсгөлд Сангийн яамны хүсэлтээр улсын төсөвт 70 тэрбум төгрөгийг 2015 оны гүйцэтгэлээс суутгахаар, үлдэгдэл мөнгийг нь 2016 оны татвар болон Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/ маягаар тооцохоор өгсөн. Харин 2016 он гарсаар АМНАТ болон аж ахуйн албан татвар ногдуулсан 64 тэрбум төгрөг байсан. Үүнээс өнгөрсөн оны буюу 2015 оны илүү төлсөн 44 тэрбум төгрөгийг тооцсон. Үлдэгдэл 20 тэрбум төгрөгийг нь бэлнээр улсын төсөвт төлсөн. Тиймээс улсын төсөвт орох ёстой 64 тэрбум төгрөгийг 2015 он болон 2016 ондоо хуваагаад төлөгдсөн гэсэн үг. Түүнчлэн бид орон нутагтаа найман төрлийн татварыг төлдөг. Тухайлбал, гаалийн, нийгмийн даатгалын шимтгэл, газар, усны, агаарын бохирдлын төлбөр, хүн амын орлогын албан татвар гээд бүх татваруудыг төлж байгаа. Өнөөдөр эхний найман сарын байдлаар эдгээр татварууд болох 70 тэрбум төгрийг орон нутагтаа төлчихсөн байгаа. Тиймээс бид улсын төсөвт Ц.Нямдоржийн хэлээд байгаа шиг 20 тэрбум бус 134 тэрбум төгрөг төлөөд байна” гэлээ. Тиймээс Ц.Нямдорж гишүүний яриад байгаа 20 тэрбум төгрөг гэдэг нь 2016 онд “Эрдэнэт” үйлдвэр улсын төсөвт бэлнээр нь төлсөн татварыг яриад байгаа хэрэг ажээ. Гишүүн маань улс төр хийх зорилгоор энэхүү худал мэдээллийг цацсан уу, эсвэл үнэхээр Татварын ерөнхий газар дутуу мэдээлэл өгөв үү. Эсвэл хэвлэл мэдээллээр цацагдаад байгаа шиг үнэхээр тэрбээр Ерөнхийлөгчид өрсөлдөхөөр сурталчилгаагаа “Эрдэнэт” үйлдвэрийн энэхүү асуудлаар шоу хийв үү. Юутай ч сүүлийн хэд хоног нийгэмд тус үйлдвэрийн санхүү эдийн засгийн үйл ажиллагаа нь хууль зөрчөөд буруу яваад байгаа юм шигээр ойлгогдох мэдээлэл хуурай өвсөнд ноцсон гал шиг л хурдтай тархлаа.

**“Эрдэнэт” үйлдвэр, “Оюутолгой” ХХК-д мөрдөж буй АМНАТ-ийн хувь хэмжээг хүснэгтээр үзүүлэв**

| Зэсийн үнэ, $тн | Эрдэнэт үйлдвэр ХХК | | | Оюутолгой ХХК |
|---|---|---|---|---|
| | Суурь 5% | Нэмэлт төлбөр | Нийт АМНАТ | Нийт АМНАТ |
| 0-5000 хүртэл | 5% | 0% | 5% | 5% |
| 5000-6000 хүртэл | 5% | 11% | 16% | 5% |
| 6000-7000 хүртэл | 5% | 12% | 17% | 5% |
| 7000-8000 хүртэл | 5% | 13% | 18% | 5% |
| 8000-9000 хүртэл | 5% | 14% | 19% | 5% |
| 9000 ба түүнээс дээш | 5% | 15% | 20% | 5% |

*Мэдээллийн дараа “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирал Ц.Даваацэрэнгээс зарим асуултад хариулт авлаа.*

**-“Эрдэнэт” үйлдвэрт шахааны бизнес байдаг гэх мэдээлэл байдаг. Үнэхээр ийм асуудал байдаг юм уу?**

-Ер нь бол үүнийг улс орон даяараа мэдэж байсан зүйл. Бүгд л ярьдаг байсан. “Эрдэнэт” үйлдвэрт шахааны бизнес байсан уу гэвэл байсан. Үүнийг ганцхан тооноос харж болно. Тухайлбал, 2013 оны бизнес төлөвлөгөөнд нэг тонн цэвэр зэсийг үйлдвэрлэх өөрийн өртөг 6625 төгрөг байсан. Өнөөдөр 2016 оны найман сарын гүйцэтгэлээр нэг тонн цэвэр зэс үйлдвэрлэх өөрийн өртөг 3950 төгрөг байгаа. Энэ зардал яаж буурсан юм гэдэгт олон зүйл нөлөөлсөн. Нэгдүгээрт, илүү гардаг зардлыг бид хэмнэж чадсан. Хоёрдугаарт, зах зээлээс олж авдаг сэлбэг бараа, материалуудыг бид аль болох хямд үнээр буюу үйлдвэрлэгчээс нь олж авахыг хичээсэн. Үүний үр дүнд өнөөдрийн хэмнэлт гарсан гэж үзэж байгаа. Ер нь сүүлийн гурван жилийн хэмнэлтийн бодлогын үр дүнд 250 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. Энэ бол нэг тонн цэвэр зэсийг ямар үнээр үйлдвэрлэж байна вэ гэдэг өөрийн өртгийн дүн бол бидний явуулж байгаа бодлогын үр дүн гэсэн үг.

**-Ц.Нямдорж гишүүн төр “Эрдэнэт” үйлдвэрийн 51 хувийнхаа эрхийг алдчихсан гээд байгаа. Үнэхээр алдчихаад байгаа юм уу?**

-“Эрдэнэт” үйлдвэрийн 51 хувь төрдөө байж л байгаа. Өнөөдөр төрийн 51 хувийг өөрчилсөн буюу хэн нэгэн хүнд дамжуулсан гэдэг мэдээлэл би аваагүй байна. Би 2013 оны хоёрдугаар сарын 01-нд Төрийн өмчийн хорооны удирдах зөвлөлийн хурлаар 51 хувийн төлөөлөл болж, энэ үйлдвэр дээр очсон хүн шүү дээ. Тэгээд өнөөдөр хүртэл энэ томилгоон дээрээ сууж л байна. Тиймээс 51 хувийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн гэдэг ойлголт байхгүй.

**-“Эрдэнэт” үйлдвэрийн 51 хувийг та бүхэнд мэдэгдэхгүйгээр өөр ямар нэгэн газрын мэдэлд очих боломжтой юу?**

-Монгол Улсын компанийн тухай хууль дээр тухайн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа бусдад буюу гуравдагч этгээдэд худалдах бол нөгөө хувьцаа эзэмшигчид заавал мэдэгддэг. Улмаар урьдчилан давуу эрхээ худалдан авах процессоо хэрэгжүүлсэний дараа гуравдагч этгээдэд худалдан борлуулах эрх нь нээгддэг. Тиймээс “Эрдэнэт” үйлдвэрийн хувь ч 49 хувийг зарах бол 51 хувьд мэдэгдэх ёстой. Харин 51 хувийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа зарах бол 49 хувийн хувьцаа эзэмшигчид мэдэгдэх учиртай. Тиймээс бидэнд мэдэгдэхгүйгээр өөр ямар нэгэн газрын мэдэлд очих боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

## Орон сууцуудыг өрийн бичгээр худалдаалахыг санал болгов

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат өчигдөр Улаанбаатарын худалдааны танхимын болон бизнес эрхлэгчдийн СЕО клубын төлөөлөл, бизнес эрхлэгчдийг хүлээн авч уулзлаа. Төр ганцаараа зүтгээд улс орноо эдийн засгийн хүндрэлээс гаргаж чадахгүй, ард түмнээ түшиж, хувийн хэвшлээ дэмжих замаар хамтарч ажиллах хэрэгтэй. Үүний тулд Улаанбаатарын худалдааны танхим болон СЕО клубын зүгээс тодорхой асуудлаар Ерөнхий сайдад танилцуулга хийж, гарц шийдэл ярихаар уулзалтад ирснээ “Петровис” компанийн ТУЗ-ийн дарга Ж.Оюунгэрэл хэллээ. Уулзалтад ирсэн бизнесийн төлөөллүүд, борлуулагдаагүй байгаа орон сууцны барилгуудыг эргэлтэд оруулах, зах зээл дээрх бэлэн мөнгөний урсгалыг хэрхэн нэмэгдүүлэх, боломж, уул уурхайн салбарт экспортын нэг цонхны бодлого баримтлах, Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэх арга замыг танилцууллаа. Мөн Буянт-Ухаад аялал жуулчлалын бүс байгуулах замаар Улаанбаатарыг бүс нутгийн хөгжлийн төв болгох талаар тус Танхимын зүгээс боловсруулсан зарим төслийг Ерөнхий сайдад товч танилцуулж, ярилцлаа. “Ард санхүүгийн нэгдэл” корпорацийн захирал Ч.Ганхуяг “Бодлогын алдаа гаргаснаас болж ипотекийн зээл өнөөдөр барилгын компаниудын үйл ажиллагааг л тэтгэж, байрны үнийг хэт хөөрөгдлөө. Өнөөдөр зарим хүн хоёр, гурав дахь байраа энэ зээлээр авч байна. Гэвч гэр хорооллын айлуудын тоо буурсангүй. Иймд одоо бэлэн болсон 35 мянга орчим орон сууцыг Улаанбаатар хотын баталгаатай өрийн бичгээр борлуулах хувилбарыг давхар ашиглавал борлуулалт нэмэгдэх, эдийн засагт бэлэн мөнгөний урсгал нэмэгдэх боломжтой” гэв. Бизнесийнхэн энэ мэтээр саналаа хэлж, Ерөнхий сайдын хэлсэнчлэн цаашдаа тодорхой нэг асуудлаар, эсвэл нэг төслөөр дагнасан уулзалт хийж үр дүнг нь үзэж байхаар тохирлоо. Мөн Ерөнхий сайдын дэргэд бизнес, хувийн хэвшлийнхэн оролцсон байнгын ажиллагаатай бүтэц байгуулах талаар ч санал солилцов. Энэ удаагийн уулзалтаар бизнесийнхний танилцуулсан Буянт-Ухаад аялал жуулчалын бүс байгуулах талаар дахин ярилцах, холбогдох судалгааг нь хийх, Засгийн газрын түвшинд хийж байгаа бодлого, судалгаатай уялдуулахаар боллоо.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## МАН сонгуулийг луйвардах боломжтой гэв

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдөр өргөтгөсөн хуралдаан хийлээ. Хурлаар ирэх оны төсөв болон орон нутгийн сонгуулийн талаар хэлэлцжээ. Бүлгийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар УИХ дахь АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн З.Нарантуяа нар мэдээлэл хийлээ. УИХ дахь АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ “Бид сөрөг хүчин гээд бүх зүйл дээр сөрөг байр суурь бариагүй. Төсөв, санхүүгийн хувиарлалт дээр болохгүй байгааг нь хэлж, болж байгааг нь дэмжээд явна. Төсөв дээр АН-ын бүлгээс ажлын хэсэг гарч ажиллана. Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн З.Нарантуяа ахална. Мөн орон нутгийн сонгуулийн сурталчилгааны хугацаанд асуудал их гарч байгааг хэлээд нэр дэвшигчдийг бүртгэхгүй байх, хасах зэрэг үйлдэл их гарч байна гэв. Мөн Сонгуулийн хороо 3:6 харьцаагаар байгуулагдаж байгаа учраас сонгуулийг луйвардах, улмаар олонхиороо хүч түрж шийдвэр гаргах боломжтой” гэв. Харин УИХ-ын гишүүн, УИХ дахь Зарлагын хяналтын дэд хорооны дарга З.Нарантуяа “2017 оны төсвийн хууль, дагаж орж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл, 2018, 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл бол ирэх гурван жилд улс орны эдийн засгийн хүнд нөхцөл байдлаас гаргах гол бодлогын баримт бичиг байх ёстой. Гэтэл бодлогын хэмжээнд шинэчлэл хийгдэх зүйл харагдахгүй байна. Алдагдал ДНБ-ний 9.9 хувьтай буюу нийт 2.6 их наяд төгрөг байхаар орж ирсэн байна. 2016 оны тодотголыг хийхдээ оны эцсээр 1.7 их наядын алдагдал байхаар байна гэж төсөөлж байсан. Өнөөдөр алдагдал 2.6 их наяд байхаар нэмэгдэж орж ирсэн байна. Энэ алдагдал нэмэгдсэн шалтгаанаа уул уурхайн үнийн өсөлт явагдахгүй гэсэн төсөөллөөр тооцоолсон байна. Алдагдал ирэх гурван жилд дорвитой буурахгүй юм байна. Мөн өр, зээлийн хэмжээ буурахгүй нэмэгдэхээр орж ирж байна. 2017 оны төсвийн хууль дээр нийт Засгийн газрын өр, баталгааны хэмжээ 2.8 их наядаар орж ирсэн байна. Энэ нь 2.6 их наядын алдагдал дээрээ нэмээд 2.8 их наядын өр тавихаар оруулж ирсэн. Энэ өрөө юунд зарцуулах гэж байгаа нь тодорхойгүй байна. 2016 оны төсвийн тодотголоор бодит гарахаар хүлээгдэж байгаа зарлага нь 8.5 их наяд төгрөг гэж баталсан. Гэтэл өнөөдөр бодит гүйцэтгэл нь 6.9 их наяд байна. Ийм зөрүүтэй тоонуудыг оруулж ирээд байна. Энэ Засгийн газрын хэрэгжүүлж байгаа арга хэмжээ эдийн засгийг хямралаас гаргаж чадахаар байна уу гэдэгт Ардчилсан намын бүлгийн ажлын хэсэг дүгнэлт гаргана” гэлээ.

## Манай улс хиймэл дагуултай болно

Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхэд өчигдөр Монголын анхны хиймэл дагуулын нэр, ажлын явцыг танилцууллаа. Энэхүү хиймэл дагуулыг Монгол Улсын их сургууль 2017 оны хавар Олон улсын “Birds” төслийн хүрээнд хөөргөхөөр ажиллаж байгаа юм. Уг хиймэл дагуулыг хөөргөхөд анх төсөвлөсөн зардлаас валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж, 100 сая төгрөг нэмж шаардлагатай болжээ. Тиймээс хиймэл дагуул хөөргөх ажлын хэсгийнхэн Шадар сайд У.Хүрэлсүхэд хандаж Засгийн газарт уламжилжлуулжээ. Засгийн газар энэ асуудлыг ирэх оны төсөвт суулгахаар болсон байна. Хиймэл дагуул хөөргөх ажлын хэсгийнхэн Шадар сайд Хүрэлсүхэд баярласнаа илэрхийлж, хиймэл дагуул хөөргөх ажлын явцын талаар танилцууллаа. Хиймэл дагуул хөөргөхөд шаардлагатай зардлыг улсын төсвийн тодотголд тусгаснаар энэхүү түүхэн үйл явдлын төлөвлөсөн хугацаандаа хэрэгжих боломжтой болж байгаа юм. Шадар сайд У.Хүрэлсүх “Манай улс хиймэл дагуултай болно гэдэг нь олон талын чухал ач холбогдолтой. Хиймэл дагуул хөөргөснөөр сансрын уудамд өөрийн гэсэн орон зайгаа эзэлж, бие даан судалгаа шинжилгээ явуулахын зэрэгцээ Монгол орны газрын зургийг сансраас авч, байгаль, цаг уурын гэнэтийн хүчин зүйл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэх юм. Энэ нь тэр дундаа улсын онцгой байдлын албанд маш чухал үр дүнтэй ажил болно” хэмээн хэлж ажлын хэсгийнхэнд амжилт хүслээ. Манай улс анхны “Мазаалай” хиймэл дагуулаа товлосон ёсоор ирэх оны хавар хөөргөхөөр боллоо. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Гана, Монгол, Бангладеш, Япон, Нигер улс хамтран ажиллаж байна. Түүнчлэн Япон улсын Засгийн газраас хиймэл дагуулгүй улс орнуудад нано хиймэл дагуул хийж хөөргөх боломж нөхцөлөөр хангах зорилгоор олон талын хөнгөлөлт үзүүлж байгаа юм. Энэ хүрээнд хааш хаашаагаа бичил хиймэл дагуул бүтээх ажлыг Японы “Кюүшү” технологийн их сургууль хариуцаж, Японд сурч байгаа Монгол оюутнууд болон МУИС-ийн багш, оюутнууд хийж байгаа юм. Анхны хиймэл дагуулаа хөөргөсний дараа 2019 онд дахин нэг хиймэл дагуул хөөргөхөөр төлөвлөсөн талаараа Шадар сайд У.Хүрэлсүхэд ажлын хэсгийнхэн дуулгалаа.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ





Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

## “ХӨШӨӨ” Б.БАТЗОРИГИЙН ГАЗРЫН НАЙМАА ИРГЭДИЙН ТЭВЧЭЭРИЙН “УТАС”-ЫГ ТАСАЛЖ ЭХЭЛЛЭЭ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Уг нь иргэн УИХ-ын гишүүн Б.Батзоригтой уулзах хүсэлт тавьсан юм билээ. Гэтэл өнөөдрийг хүртэл түүнийг хүн байна гэж ч тоож авч үзээгүй байна. Ядаж байхад энэ асуудал нь нэг хүнийх ч биш хэдэн зуун иргэдийн эрх ашгийг ноцтой зөрчсөн үйлдэл гэж иргэн Б.Батдэлгэр мэдэгдээд байгаа. Өнөөдөр ганц хүн ордны гадна зогсч байна. Цагдаад нар нь ирээд бариад явдаг юм байна. Маргааш, нөгөө хэдэн зуун хүн дарга нараас хариуцлага нэхвэл яах вэ. Б.Батзориг гишүүн балгаа баллуурдаж, засаагүйгээр барахгүй, Төрийн ордонд томорч суусны гайг хэн засах юм. Өнөөдөр нам эвсэл гэж нэгнээ хаацайлах биш, шаардлагатай бол хариуцлага нэхэх л ёстой. УИХ, МАН-ын дарга М.Энхболд энэ асуудалд анхаарал хандуулж, иргэдээ жаахан ч болов өмөөрмөөр байна. Ер нь Б.Батзориг гэдэг хүний тарьсан балаг үүгээр дуусахгүй шүү дээ. Өмнө нь бас л газрын асуудлаас үүдэлтэй Баянзүрх дүүргийн иргэн Г.Базарсүрэн, Л.Тунгалаг нар шүүх дээрээ тулж л байсан. Эцэстээ нэг нь хохироод л үлдсэн. Баримттайгаа цахим сайтуудаар дүүрэн байгаа, энэ мэдээлэл. Ерөөсөө Баянзүрх дүүргийн иргэд түүний хийсэн газрын наймааны балгийг даахаа болиод, тэвчээрийнх нь “утас” тасарч эхэлжээ гэж дүгнэж болохоор байна.

Дээрээс нь өнөөдөр хүртэл энэ хүнээс “хөшөө” тодотгол нь зүүгдээстэй л яваа. Баянзүрх дүүргийн Засаг даргаар ажиллаж байхдаа хэдэн хөшөө барьснаас өөр юм бараг хийгээгүй гээд хэлчихвэл холуур зөрсөн болохгүй дээ. Ер нь өнөөдөр хамгийн хөгжил муутай дүүргийг нэрлэ гэвэл Баянзүрх л аманд орж ирнэ. Улаанбаатар хотод цэцэрлэг, сургуульгүй хорооныхоо тоогоор бараг л тэргүүлж яваа байх. Саяхан л тийм байсан юмдаг. Сонгинохайрхан аргагүй их хүн амтай болохоор дөхөж очдог нь хаашаа юм гэхээс. Гэтэл энэ нөхөр сургууль, цэцэрлэг барихын оронд хөшөө босгоод л явж байж. Бодвол хөшөө барьж, мөнгө олдог байсан юм байгаа биз. 2012 оны гуравдугаар сарын сүүлчээр түүнийг АТГ-аас шалгаж байсан билээ. Тэр үед түүнийг АТГ-т шалгуулахаар хүсэлт гаргасан Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны иргэн Ч.Бат-Эрдэнэ тухайн үедээ хөшөөний асуудлыг маш нарийн ярьж байсан байгаа юм. Тэрбээр “Эвтэй дөрвөн амьтан” хөшөөг 350 сая төгрөгөөр бариулсан гэсэн. Гэтэл хоёр метр өндөртэй бурхан багшийг 30 сая төгрөгөөр бүтээдэг юм байна. Тэр хөшөөг бүтээсэн багийнхнаас “Эвтэй дөрвөн амьтан” хөшөөг хэдэн төгрөгөөр бүтээх талаар асуухад дээд тал нь 30 сая төгрөг болно гэдгийг баталсан. Мэргэжлийн хүмүүсийн хэлж байгаагаар ерөөсөө л арматур зангидаад, дээр нь шавар цутгаад өнгөлчихдөг юм байна. Бүр нурдаггүй герман шавар байдаг гэнэ” хэмээн ярьсан байдаг. Мөн Амгалангийн тойрогт барьсан цагаан арслан, банхарын хөшөө байна. Тэрбумаар барьсан гээд л шуугиад байдаг. Яах вэ өөрөө болохоор тэрбумаар бариагүй гэж хэлсэн. 100 асуулт 100 хариултад оролцохдоо шүү дээ. Гэхдээ тэр хөшөөг барьснаас хойш Баянзүрх дүүрэгт гэмт хэргийн гаралт, нялхсын эндэгдэл буурсан гээд хээв нэг ярьж байгаа хүнийг одоо юу гэж ойлгох вэ. Иймл л нөхдүүд өнөөдөр Монголын төрийг атгалцаж байна шүү дээ. Тэгээд өмнө нь тарьсан балаг нь одоо ч арилахгүй, нэг иргэн хоолойгоо хэрчинэ гээд л байж байна. Өнөөх “үхэр” мэтээр хараад байгаа иргэд чинь одоо та нараас хариуцлага нэхээд эхэллээ дээ. Цаашдаа ч Баянзүрхийнхэн олноороо хариуцлага нэхэх байх. Тэр болгонд цагдаа ирж баривчлаад байх уу, эсвэл тарьсан балгаа засах уу гэдэг сонголт үлдэнэ. Уг нь “хөшөө” Б.Батзориг гишүүн хийсэн газрын наймааныхаа балгийг эртхэн засчихвал зүгээрсэн дээ.

...Өнөөх “үхэр” мэтээр хараад байгаа иргэд чинь одоо та нараас хариуцлага нэхээд эхэллээ дээ. Цаашдаа ч Баянзүрхийнхэн олноороо хариуцлага нэхэх байх. Тэр болгонд цагдаа ирж баривчлаад байх уу, эсвэл тарьсан балгаа засах уу гэдэг сонголт үлдэнэ. Уг нь “хөшөө” Б.Батзориг гишүүн хийсэн газрын наймааныхаа балгийг эртхэн засчихвал зүгээрсэн дээ...

ХААН БАНК САН



ХААН БАНКНЫ НЭРЭМЖИТ
ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 2016–2017
ШИЛДЭГ 40 ОЮУТАНД сургалтын төлбөрийн тодорхой хувийг тэтгэлгээр олгоно.

**ХААН Банкны нэрэмжит "ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 2016–2017"-д эрхэм оюутан таныг урьж байна.**

**ХЭН ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ВЭ?**
Сурлагын амжилт, нийгмийн идэвхээр манлайлагч 2, 3, 4-р курсын оюутнууд

**МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ:**
2016.10.17-ны өдрийн 18:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авч, 2016.10.31-ний өдөр **ШАЛГАРСАН 40 ОЮУТНЫ** нэрийг ХААН Банкны албан ёсны цахим хуудас **www.khanbank.com**-д байршуулна.

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:**
- Тэтгэлэг хүсэгчийн анкет /анкетыг **www.khanbank.com** хаягаас татаж авна уу/;
- Их, дээд сургуулийн тодорхойлолт /элссэн он, анги зэргийг заасан/;
- Их, дээд сургуулийн дүнгийн хуулбар / сургуулийн захиргаагаар баталгаажуулсан/;
- Их, дээд сургуулийн 1 багшийн тодорхойлолт;
- Хувь хүний хөгжил, улс орны ирээдүйн талаар чөлөөт сэдвээр 400 үгтэй эссэ бичих;
- Өрхийн орлогыг батлах тодорхойлолт зэргийг ирүүлнэ.

**ТАВИГДАХ ШААРДЛАГА:**
1. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн бакалаврын зэргийн 2,3,4-р курсын оюутан байх;
2. Сурах хүсэл эрмэлзэлтэй, анги хамт олноо сурлагын амжилтаар тэргүүлэгч байх;
3. Оюутны эрдэм шинжилгээний хурал, илтгэл, уралдаан тэмцээнд тодорхой амжилттай оролцсон бол давуу тал болно;
4. Нийгэм олон нийтийн ажил, урлаг спортын тэмцээн бусад арга хэмжээнд оролцсон байх;
5. Өрхийн орлого зэргийг харгалзан үзнэ.




ХААН БАНК 9 ЖИЛИЙН ХУГАЦААНД НИЙТ 1300 ШИЛДЭГ ОЮУТАНД ТЭТГЭЛЭГ ОЛГООД БАЙНА.

Дэлгэрэнгүй мэдээллийг:
332–333 (3534) www.khanbank.com khanbank.com/facebook

Дугаарын 60 мөр

## Гэр бүлийн хуулиа чангалаач

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тухайн үед гурван ч хүүхэдтэй эрийг эхнэрээс нь салгаж, хамт амьдрах болсон эмэгтэй хүүхдүүдийнх нь нэгийг зүсч, тамласан байсан. Тэгвэл дараагийнх нь саяын хэрэг. Угаасаа гэр бүлээс гадуурхи харилцаа замбараагаа алдаж, эцэстээ хүний аминд хүрч эхэллээ. Сүүлийн үед амьдралынхаа цаг мөч бүрийг тоочиж суудаг болсон сошиал ертөнцөд “хүний нөхөртэй явалдсан, амрагласан хүнийг ичтэл нь шэйрлэ” гэх мэтээр хэн нь ч мэдэгдэхгүй охидын зургийг ихээр тараах болсон. Хотод бол энэ мэтчилэн цахим ертөнцөөр л “гэмтэн”-ийг гэсгээн цээрлүүлэх болж. Харин хөдөө, орон нутагт янаг амрагийн явдал замбараагаа алдсан гэвэл хэтрүүлсэн болохгүй. Бүр сумынхан нь бүгдээрээ мэддэг, хүлээн зөвшөөрчихсөн гэр бүл ч байдаг юм билээ. заримынхнь хүүхэд төрж, түүнийх нь эцэг хэн болохыг тэр гээд л шууд хэлж байх жишээтэй. Гэр бүлээс гадуурхи харилцаа энэ мэтчилэн хүрээгээ тэлж, гэр бүлийн нандин харилцаа, нэг нэгэндээ итгэх итгэл, бат бөх холбоо улам бүр алсран одож эхэллээ.Тиймээс Гэр бүлийн тухай хуулиа цаг үетэйгээ нийлүүлэн, чангатгах хэрэгтэй байна.

Гэр бүлийн тухай хуульд гэр бүлээс гадуурхи харилцааны талаар А үсэг ч алга. Учир нь тухайн үед гэр бүлээс гадуурхи харилцаанд орсон этгээдийг намын хурлаар авч хэлэлцээд, хатуу донгодох, батлахыг нь хураах, ажлаас нь хөөх гэх мэтчилэн арга хэмжээ авч “гэмтэн”-ийг бүх насаар нь ичихэд хүргэдэг байсан гэдэг. Тэр хэрээр нэрээ сэвтүүлэх, цаашлаад үр хүүхдээ өнчрүүлэх асуудал цөөхөн гардаг байсан нь тодорхой. Харин энэ цаг үед бол гэр бүлээс гадуурхи харилцаа үүсгэх, бүр “нууц амраг” гээчийг хүлээн зөвшөөрөх шахам л замбараагүй, ил тод болж. Зарим нь ч бүр олон эхнэр, нөхөртэй болох хууль батлагдаасай гэж хүсдэг ч байж мэдэх юм. Ямартай ч гэр бүлээс гадуурхи харилцаа, нууц амрагийн асуудал хэрээс хэтэрч, бэлгийн замын халдварт өвчин ч замаа алдаж, цаашлаад үр хүүхдийнхээ аминд хүртэл хүрч эхэллээ. Тиймээс л хуучин цагт дагаж мөрдөж байсан Гэр бүлийн хуулиа шинэчилж, чангаруулах шаардлага үүсээд байна. Хийх юм нь олдохгүй, хэлэх үгээ ч мэдэхгүй байгаа зарим гишүүд энэ мэт асуудалд анхаарлаа хандуулж, Гэр бүлийн хуулийг шинэчилчихээч.

## ЧУХАЛ ХҮН

# Г.Батбаатар:

Ч.ЧУЛУУН

*“Ази, номхон далайн бүсийн шилдэг сургууль болно хэмээн зорилго, зорилтоо тодорхойлоход минь шоолох хүн цөөнгүй байсан. Манай хамт олон үүнийг сэтгэлийн хөөрлөөр шийдээгүй. Судалж, нягтлах тусам бидэнд боломж, боломцоо ойрхон байгаа нь мэдрэгдсэн. Тиймээс сургууль, хамт олноороо хичээн зүтгэх аваас 2024 он гэхэд бүсийн шилдэг сургуулийн нэг болж чадах юм байна гэж үзсэн хэрэг”хэмээн омог бардам өгүүлж суугаа эрхэм бол анагаах ухааны салбарт өөрчлөлт шинэчлэлтийг баг хамт олныхоо дэмжлэгтэйгээр хийж байгаа АШУҮИС-ийн захирал Г.Батбаатар. Түүнтэй ярилцах тусам хийж бүтээхийн хүсэлд автсан нь мэдрэгдэнэ. Урамтай ч юм билээ. Тэдний сургуультай зорьж очоод танилцаарай. Шилэн ханаы цаана оргилох усан сангийн дэргэд оюутнууд хэд гурваараа хуучилж, зарим нь хичээлээ давтаж байгаа дүр зургийг харахад Токиогийн их сургууль л ийм байдаг байхдаа гэсэн сэтгэгдэл төрснийг нуух юун. Ийм нэг эрхэмтэй уулзсанаа танд хүргэе.*



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Нэгдүгээрт, өндөр өртгөөр байгуулсан лаборатори үйл ажиллагааныхаа зардлаа нөхөж явах ёстой. Өөрөөр хэлбэл, сургууль шаардлагатай химийн бодисыг нь худалдаж авч өгөөд явах биш. Туршилт, эрдэм шинжилгээний ажил хийх гэж байгаа багш нарт мөнгийг нь олгоод тэрхүү нээлт нь амжилттай болбол гарааны компаниуд худалдаж аваад баялаг болгон зах зээлд нийлүүлэх явдал. Үүний хамгийн тод жишээ бол бидний байгуулсан эмийн үйлдвэр. Өнөөдөр тус үйлдвэр патентжуулсан таван эмийг зах зээлд нийлүүлж эхэллээ. Өнгөрсөн долоо хоногт 50 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Энэ 50 сая төгрөгийг сургуулийнхөө төсөв рүү татчихгүй, эмийн үйлдвэрт хийж буй анхны хөрөнгө оруулалт нь болох юм. Хоёр дахь амжилттай явж байгаа гарааны компани бол үр шилжүүлэн суулгах “Өөжин Мед” эмнэлэг. Япон улсаас 850 мянган ам.долларын тоног төхөөрөмжийг оруулж ирэн гарааны компани байгуулан тусдаа гарахад нь сургуулиас нэг ч төгрөг гараагүй. Жилийн дотор 139 ээж, 139 гэр бүл үр хүүхэдтэй болоод байж байна. Одоо 17 ээж шинэ хүнээ хүлээж буй. Энэ бол манай багш нарын толгойд байсан мэдлэг баялаг бодит болж байгаагийн нэг жишээ. Мөн “Мон Ай Ти” компанийг байгуулсан. Ирэх 2018 оны зургадугаар сард шинэ эмнэлэг ашиглалтад орно. Энэ эмнэлэг цаасгүй эмнэлэг болох учиртай. Тэрхүү программыг худалдаж авбал 2-3 тэрбум төгрөг болно. Бидэнд тийм хэмжээний мөнгө байхгүй тул залуучуудаа сургаж давтан сургалтад хэд хэдэн удаа хамрагдана. Эмнэлэг ч ашиглалтад орно, тоног төхөөрөмжөө ажиллуулах эмч нар нь ч бэлэн байх юм. Хажууд нь монгол анагаах ухааны олон улсын сургуулийн барилга, 80-100 ортой эмнэлгийн барилгын хамт баригдаж байгаа. Эмнэлгийнхээ бүх тоног төхөөрөмжийг Хятадын ӨвөрмонголынТүньЛяньхотын Монгол үндэстний их сургууль нийлүүлж байгаа. Дашрамд өгүүлэхэд, манай сургууль 11 мянга гаруй оюутантай, 1000 орчим багш, ажилчидтай, өнөр өтгөн айл. Тиймээс сургуулийн захиргаа ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэх үүднээс шнээр баригдаж буй эмнэлгийнхээ хажууд 180 айлын орон сууц барихаар төлөвлөж, газрынхаа асуудлыг шийдүүлэхээр Нийслэлийн газрын албанд хүсэлтээ хүргүүлсэн. Улсын төсвөөс нэг ч төгрөг гарахгүй. Ипотекийн зээлийн асуудлаа ХААН банкны захирлуудын зөвлөлөөр шийдүүлсэн. Бас нэг гоё юм нь мкв нь 950 мянган төгрөгөөр баарьж өгөе гэсэн компани байна. Багш нар маань баяртай байгаа.

**-АШУҮИС-ийн дипломыг Европын холбооны улс хүлээн зөвшөөрсөн байна?**

-Монголын боловсролын салбарт төдийгүй анагаах ухааны салбарын түүхэнд тэмдэглэгдэн үлдэхүйц амжилтын суурийг бид тавьж чадсан. Энэ нь Европын холбооны ACEM гэж байгууллагаар хүний их эмч бэлддэг хөтөлбөрөө магадлан итгэмжлүүллээ, өнгөрсөн зургадугаар сард. Энэ бол маш том амжилт, бас том ололт. Өөрөөр хэлбэл, манай

# МАНАЙ ХАМТ ОЛОН АЗИ, НОМХОН Д
# БОЛОХЫН ТӨЛӨӨ ХИЧЭ

**-АШУҮИС-ийн үүдээр ороход уулга алдахуйц өөрчлөгджээ. Та бид хоёр өнгөрсөн жилийн өдийд ярилцаж байхад бүтээн байгуулалтуудын ихэнх нь төслийн шатандаа явж байсан шүү дээ?**

-АШУҮИС-ийн хамт олон Ази, номхон далайн бүсийн шилдэг сургууль болох зорилт тавин ажиллаж байна. Энэ тухайгаа анх зарлахад шоолох хүн цөөнгүй байсан. Бид маргаашаа тодорхойлохдоо сэтгэлийн хөөрөлд автаагүй. Судалж, нягтлах тусам бидэнд боломж, боломцоо ойрхон байгаа нь мэдрэгдсэн. Тиймээс сургууль, хамт олноороо хичээн зүтгэх аваас 2024 он гэхэд бүсийн шилдэг сургуулийн нэг болж чадах юм байна гэж үзсэн хэрэг. Бүсийн шилдэг их сургууль болохын тулд юун түрүүнд эхний шалгуур болох оюутны сурах орчныг бүрдүүлэх явдал. Оюутнууд нь сурч боловсрох, багш нар нь ажиллах нөхцлөөр хангагдсан, анги танхим нь бүрэн тоноглогдсон тийм орчныг бүрдүүлэх нь бидний хамгийн түрүүнд хийхээр төлөвлөсөн ажил байлаа. Би 2014 онд Чех улсад болсон ACEM-ын ректоруудын уулзалтад очоод хамгийн түрүүнд олж харсан, анзаарсан, зүйл маань ч энэ. Үнэндээ ЕБС төгссөн хүүхэд их, дээд сургуульд элсэн суралцлаа гэсэн чинь таазных нь шохой хуурчихсан, шал нь цөмөрчихсөн, хана туурга нь гэж хачин, малын сараалжнаас ялгарах юмгүй зүйл рүү яваад орчихвол тухайн хүүхэдэд сурах мэдрэмж төрөх үү. Гоё, сайхан орчинд хөл тавьсан оюутан ямагт сэтгэл хангалуун явна шүү дээ. Энэ бүхнийг ажил хэрэг болгохын тулд эхлээд хөгжлийн бодлогын төвшинд авч үзэн нэгдүгээрт, сурах орчноо сайжруулъя. Хоёрдугаарт, сургалтын хөтөлбөрөө шинэчилье, гуравдугаарт, багш нараа хөгжүүлье гэсэн гурван зүйлд анхаарлаа хандуулсан. Зөв чиглүүлж, нөөц боломцоогоо зөв ашиглаж чадвал улсын сургуульд ч боломж байдаг л юм байна. Өнгөрсөн хичээлийн жилд номын сангаа ашиглалтад оруулснаар суудлын тоо 850-иар нэмэгдлээ. Өмнө нь 700 суудалтай байсан юм. Эдүгээ ашиглагдаж байгаа хичээлийн байрныхаа талбайг дахин хуваарилж, интернэтийн, бүлгээр хичээллэх танхимыг шинээр байгуулж, анги танхимаа бүрэн тохижууллаа. Орчин нөхцөл сайжраад ирэхээр сурах бичгээ шинэчлэх шаардлага тулгарч 60 гаруй сая төгрөгөөр дэлхийн шилдэг их сургуулиудад хэрэглэгддэг магистрантуудад зориулсан сурах бичгүүд худалдан авч номынхоо фондыг шинэчилж, түүнийгээ онлайн болгоод заавал номын санд ирэхгүйгээр гэрээсээ шууд татаж авдаг нөхцлийг бүрдүүллээ. Намайг сургуулийн захирлаар томилогдох үед оюутнууд коридороор шуугиад л, ангийн хаалга хаагдмац коридор тэр аяараа харанхуй болдог байв. Тиймээс энэ орчныг өөрчлөх ёстой гэж үзэн оюутнууддаа зориулан 800 мкв эко цогцолборыг байгуулсан. Үүний үр дүнд оюутны бие даан суралцах нөхцөл 70 хувиар нэмэгдсэн. Эл амжилттай зэрэгцээд КОЙКА олон улсын байгууллага манай сургуулийг дэмжиж “Багшийн хөгжил” төслийг хэрэгжүүлэх боломжийг олгосон. Төслийн хүрээнд мастер багш бэлтгэх сургалтад маш багш нараа хамруулсан. Өмнө нь сайн эмч бэлдэж байснаас сайн багш бэлтгэх тухайд анхаарч байгаагүй юм билээ. Гэтэл үнэндээ сурган заах арга зүйг эзэмшсэн хүн л хүнд юм хэлж өгч чаддаг аж. Сайн эмч, сайн багш хоёрт газар тэнгэр шиг том ялгаа бийг бид олж харсан. Тиймээс эл асуудлыг шийдэх үүднээс Канадын Калгеригийн их сургуультай хамтарч төсөл хэрэгжүүлэн багш нараа сургалтад хамруулсан чинь тэдний маань нүд нээгдэж, үзэл бодол их өөр болж ирсэн. Хамгийн гол нь багш хүн оюутнууддаа мэдлэг олж авах гэдэг арга замыг зааж өгөөд түүнийгээ өөрийн болгож, эзэмшиж чадаж уу гэдгийг шалгах тийм л үүрэгтэй гэдгээ ухамсарласан явдал. Үүний үр дүнд багш нарын оюутандаа зориулах цаг нь багасч тэр хэрээр өөрийгөө хөгжүүлэх завтай болж байгаа юм. Эдүгээ манайд дэлхийн топ 500 их сургуульд докторын зэрэг хамгаалсан 70 багш ажиллаж байна. Харамсалтай нь тэдэнд маань эрдмийн ажлаа үргэлжлүүлэх нөхцөл байгаагүйн улмаас оноплдсоор ирсэн. Тэгэхээр нь улсаас дэмжлэг авч, таван тэрбум төгрөгөөр байгуулсан цөм лабораторио ашиглалтад оруулах цаашлаад судалгаа, шинжилгээгээ хийх орчныг нь бүрдүүлэх санхүүжилтийн эрэлд гарч 2015 оноос гранд зарлаад эхэлсэн. Өнгөрсөн 2015 онд 500 сая, 2016 онд 870 сая төгрөгийн гранд зарласан бол энэ хичээлийн жилд тэрбум төгрөгийн үнэлэмжтэй грандыг зарлах гэж байна. Түүнчлэн Нүүр ам судлалын сургуулийнхаа дэргэд 1700 мкв жижигхэн зургаан давхар эмнэлгийн өргөтгөл бариад эхэлсэн.Энэ ондоо ашиглалтад авна. Чингэлтэй дүүргийнхэнд шүдний тусламж үйлчилгээг хүлээлт, чирэгдэлгүй хүргэх боломж бүрдэж байгаа юм. Нөгөөтэйгүүр, манай шүдний эмч нарын мэргэжил дээшлүүлэх болон резидентийн сургалтууд тэнд явагддаг. Энэ мэтчилэнгээр их сургуулийнхаа ойрын ирээдүйг их сайхнаар харж байна. Эцэст нь хэлэхэд, 2018 оны есдүгээр сарын 1-нд буюу 2019 оны хичээлийн жилд бид шинэ эмнэлэгтэй, шинэ технологитой, шинэ боловсон хүчинтэй, шинэ бодлоготой гэхчилэн бүх юм нь шинэ хичээлийн жилээ эхлүүлэхийн төлөө мэрийн ажиллаж байгааг энд зориудаар онцлох нь зөв байх. Бүсийн шилдэг сургуулийнхаа болзлыг ч хангасан байх биз. Энэ бүхнийг Батбаатар би нэр алдар олохын төлөө хийж байгаа юм биш шүү дээ. Монгол Улсын боловсролын салбарт АШУҮИС жишиг тогтооё гэсэн том зорилгыг тээсэн хэрэг. Тэгээд ч бид их сайхан цаг үед ажиллаж, амьдарч байна шүү дээ.

**-Уучлаарай, яриаг тань таслах нь грандынхаа зорилгыг хэлж өгнө үү?**

-Ийм хоёр зорилготой.

...эхэлсэн. Сая есдүгээр сарын 2-нд нээлтээ хийсэн. Маш гоё программ болсон байна лээ. Түүнийгээ шинэ эмнэлэгтээ ашиглаад зогсохгүй бусад эмнэлгүүдэд худалдана.

**-Баярлалаа, танд. Шуугиан тариад байгаа Кибер их сургууль байгуулсан тухайгаа сонирхуулаач?**

-Өнгөрсөн жил цаг хугацаа, орон зай, нөхцөл боломцооноос үл хамаарч мэдлэг олж авах боломж бүхий кибер их сургуулийг байгууллаа. Олон улсын кибер их сургуульд маань одоогийн байдлаар Багануур, Өвөрхангай, Говь-Алтай, Баян-Өлгий, 127 эмч ажлаа хийнгээ мастерт сурч байгаа. Өнгөрсөн хавар Хятадаас 53 хүн, Японоос хоёр, Солонгосоос 14 хүн шинээр элссэн. Манай их сургуулийн дэргэдэх кибер их сургуулийн нэр хүнд Азид сайн байгаагийн илэрхийлэл гэж бид ойлгож байгаа .

**-Шинэ эмнэлгийн тань хүчин чадлын талаар нэмж тодруулъя?**

-Шинэ эмнэлэг Баянзүрх дүүргийн XII дугаар хорооны нутаг дэвсгэр дээр баригдаж байгаа. Монгол Улсад төдийгүй бүс нутагтаа хамгийн өндөр төвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүргэдэг эмнэлэг байх болно. “ЖАЙКА”-гийн техникийн хамтын ажиллагааны газарт хандан төсөл хэрэгжүүлэх хүсэлт гаргасан нь дэмжигдэж, өнгөрсөн долоо хоногт хоёр тал гарын үсэг зурлаа. Төслийн хүрээнд 150 гаруй эмч, техникийн ажилчид Японд мэргэжил дээшлүүлнэ. Нэг хүн нэг удаа явахгүй, сургуулийн дипломыг Европын холбоо хүлээн зөвшөөрсөн гэсэн үг. Манай сургуулийн дипломыг Азийн цөөхөн орон АНУ-аас Калифорниа муж л хүлээн зөвшөөрдөг байсан. Эдүгээ Европын холбоо тэр чигтээ зөвшөөрч байгаа нь манай сургуулийн төгсөгчдөд Европын зах зээлд ажиллах боломж нээгдэж байгаа юм. Энэ бол их сайхан мэдээ.

**-Оношлогооны маш том төв ашиглалтад оруулах нь миний бас нэг мөрөөдөл гэж та өнгөрсөн жил ярьж байсан. Энэ ажил тань юу болсон бэ?**

-Эрүүл мэндийн яамнаас 33 өвчнийг оношилж чадахгүй, эмчилж чадахгүй байгаагаа зарласан. Жилд 40 мянга гаруй хүн Солонгос, Хятад, Япон руу зөвхөн оношлуулах гэж явдаг. Тэдний мөнгийг Монголдоо үлдээхийн тулд энэхүү оношилгооны төвийг байгуулахын төлөө гүйгээд байгаа юм. Японы ЖАТА гэж төрийн бус байгууллагад “Японы ард түмний хөрөнгөөр сайхан эмнэлэгтэй болж байгаа юм чинь одоо оношилдог болмоор байна шүү дээ” гэсэн хүсэлт тавьсан. Төслийг маань дэмжсэн. Азид байхгүй тийм оношилгооны төвийг 2018 онд Улаанбаатарт байгуулна. Судалгааны ажил нь ч хийгдээд эхэлсэн. Энэхүү төв зөвхөн монголчууд бус Монгол Улсыг тойрсон Казакстан, Тува, Буриад, Өвөрмонголыг оруулаад 30 сая хүнд үйлчлэх юм. Бид 2018 зургадугаар сар гэхэд оношилгоо шинжилгээний төвийг ашиглалтад хүлээн авах байх. Монголын эрүүл

# ЧУХАЛ ХҮН

мэндийн салбарт маш том үсрэлт болно. Дээрээс нь бид аль болох хямд чанартай үйлчилгээ үзүүлэхийг хичээх болно. Японы ЖАТА-гийн нөхдүүд тус төвийг түшиглээд уул уурхай, хүнс, хими, эрүүл мэндийн төв лаборатори байгуулья гэж байгаа юм. Манай уул уурхайнхан янз бүрийн сорьцоо Австрали руу явуулдаг юм билээ. Тийшээ явуулж хэдэн зуун мянгаар доллар төлж байхын оронд дотооддоо шинжлүүлсэн нь дээр биз дээ. Хүнсний аюулгүй байдлыг тодорхойлдог лавлагаа лаборатори Монголд байтугай төв Азид алга. Үүнийг байгуулна. Манай их сургууль одоо 20 ортой жижигхэн “Эрхэс” гээд клиник эмнэлгийг ажиллуулж байна. Йонсэй их сургуулиас долоон профессор урьж авчираад нарийн төвөгтэй чих, хамар хоолой, нүд, хэвлийн хөндийн гээд бүх хагалгаануудыг хийж буй. Эмнэлгийнхээ хүчин чадлыг сайжруулахзорилгоорСолонгос дахь Олимпус компаниас дурангийн аппаратыг үнэ төлбөргүй авахаар болсон. Үндсэндээ дурангийн оношилгоо эмчилгээний төв манайд төвлөрч байгаа хэрэг.

**-Танай эмийн үйлдвэрийн анхны бүтээгдэхүүн ямар нэртэйгээр зах зээлд хөл тавив?**

-Манай Даваасүрэн, Цэцэгмаа, Дүнгэрдорж, Энхжаргал, Даваадагва, Пүрэвсүрэн, Мөнхбат нарынхаа профессоруудын оюуны бүтээлийг олон улсын зах зээлд гаргах эхний алхмаа хийсэн. Тамир сэлбэх, өвчин намдаадаг бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн. Ялангуяа, тамиржуулагч нь өндөр настан Ийм цай хийдэг юм байна гээд харж суугаа байх. Одоо маркетинг дээрээ анхаарна. Бас нянгаас 99 хувь хамгаалдаг саванг манайхан үйлдвэрлээд эхэлчихлээ. Эхний туршилтууд амжилттай болсон. Үүндээ урамшаад гоо сайхны, батганы эсрэг саван үйлдвэрлэхээр туршсан. Түүнчлэн фитнессээр хичээллэж байгаа хүмүүст зориулж хоргүй ураг үйлдвэрлэнэ. Гаднаас маш өндөр үнээр орж ирсэн уургийг манайхан хэрэглэдэг. Манай эрдэмтэд ингэж мундаг ажиллаж байгаа тул гарааны компанийг нь байгуулж өгнө. Яагаад миний амнаас гарааны компани гэдэг үг гараад байна вэ гэвэл дэлхийн нэр хүнд бүхий их сургуулиудын амжилтад хүрсэн нууц нь үүнд оршиж байгаа юм. Жишээ нь, Харвардын их сургууль 35 мянган гарааны компани төрүүлсэн бол Эм Ай Ти буюу Массачусетсийн технологийн их сургууль 42 мянган гарааны компанитай. Харвардын их сургуулийн Хөгжлийн бодлого хариуцсан захиралтай нь уулзсан. Компаниуд нь хамгийн багадаа дунджаар 20 мянган ам.долларыг сургуульдаа өгдөг гэхээр 35 мянган компанийг 20 мянган ам.доллараар үржүүлэхээр тийм хэмжээний мөнгө тэр сургуульд ашиг болж орж ирж байгаа байхгүй юу. Манай сургууль найм дахь компаниа байгуулаад явж байна. Бүх зүйл хуулийн дагуу явж байгаа. Гарааны компанийн хууль гэж бий. Мэдээж сургууль патентыг нь эзэмшиж 10-15 хувийн ашгийн татвар авна.Гарааны компани өсч дэвжих ёстой. Сургууль тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй. Бид **гэж бодож суулаа?**

-Би эгэл жирийн сэхээтний гэр бүлд өсч торнисон. Манай удамд эмчийн мэргэжил эзэмсэн нь ганцхан би. Ээж маань бүхий л насаа эрдэм шинжилгээний ажилд зориулсан хүн. Аав инженер. Харамсалтай нь, залуугаараа бурхны оронд мордсон. Би аавынхаа хурдан сэтгэдгийг нь дуурайсан байж мэднэ. Хамгийн гол нь би зүтгэж байж энэ амжилтад хүрсэн. Өглөөний 07:30 цагт сургууль дээрээ ирж, орой 20:30 гээд гэртээ харьдаг гэхээр өдөрт дунджаар байгааг, юуг засч сайжруулах ёстойг гарын таван хуруу шигээ мэддэг. Хоёдугаарт, долоо хоног бүрийн даваа гарагийг сургуулиуд болоод оюутан сурагчдынхаа хичээлийн явц байдалтай танилцахад зориулдаг. Хүн дагуулж, сүржигнэдэггүй. Чимээгүй гараад л алхчихдаг юм. Анги танхимын тохижилт, багш нарын суух ширээ, сандал ямар байгааг нь хараад өнгөрдөг. Болж бүтэхгүй байгааг нь хийх ажлын төлөвлөгөөнд суулгаж өгөөд захирлын зөвлөлөөр оруулдаг. Манай сургуулийн дарангуйлагдаж байна, түүнийг яаж засч болох вэ, үр дүн нь ямар байна вэ” гэдэг сэдвээр хамгаалсан. Шавь нар маань ч энэ л сэдвийн хүрээнд магистр, докторын зэрэг хамгаалж буй. Саяхан тооцоолж үзсэн чинь 20-оод доктор, 30 орчим магистрын ажил удирдсан байна лээ. Энэ хэрээр зөвхөн дархлаа судлалын чиглэлээр ажилладаг бүхэл бүтэн арми бэлтгэгдсэн гэсэн үг. Түүгээрээ бахархдаг. Багш хүн шавиараа бахархдаг гэдэг биз дээ. Олон сайхан шавь нартай болжээ. Дархлаа судлал гэдэг номыг бид долоо дахь **өвчлөл өндөр байгаа. Ийм үед дархлааг хэрхэн сайжруулах талаар та бүхэн судалсан нь дамжиггүй?**

-Хүний орчлон ертөнц макро организм, микро организмын тэнцэл дунд л байдаг юм. Энэ хоёр тэнцвэртэй байх ёстой. Микро организм давамгайлаад ирэхээр хавдар болдог. Тэгэхээр энэ хоёрын тунг нь тааруулж, тэнцвэрийг нь олж явбал хүн эрүүл байна. Үүнийг шийдэх арга нь тун энгийн. Шинэ ногоо идээд л цэвэр агаарт гүйх явдал.

**-Та эрүүл амьдрах хэв**



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ДАЛАЙН БҮСИЙН ШИЛДЭГ СУРГУУЛЬ ЭЭН АЖИЛЛАЖ БАЙГАА

болон бага насны хүүхдийн биеийн дархлааг сайжруулна. Үрэвслийн эсрэг эмүүд байна. Мөн “Голден Ру Ти” буюу алтангагнуур гэж хүний биед маш сайн гайхалтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхэлсэн. Хүн орхоодойгоос илүү үйлчилгээтэй болох нь тогтоогдсон. Тун удахгүй алтангагнуурын цайгаа сургуулийнхаа брэнд болгоно. АСЕМ-ын зочдод барьсан бэлэг дотор манай цай багтсан. Дэлхийн 53 орны төр, засгийн тэргүүн,тэднийгдагалдажирсэн нөхдүүд Монголд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль гэж байдаг юм байна. 2024 он гэхэд сургуулийнхаа нийт төсвийн 50 хүрэхгүй хувийг сургалтын төлбөрөөс бусдыг нь гарааны компаниасаа олдог болох зорилт тавин ажиллаж байгаа. Би орхисон байна, манайх “Мон Эч Пи” гээд оношлуурын үйлдвэр байгуулсан. Ходоодны хавдар үүсгэдэг хеликобактерын оношлуурыг манай багш нар үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Үнэтэй оношлуур гаднаас авах шаардлагагүй болчихож байгаа юм. Бид өөрсдөө үйлдвэрлээд савлаад эхэлсэн.

**-Таныг ярьж байх хооронд би “Батбаатар захирал ямар хүний үр сад юм бол доо”**

13 цаг ажилладаг. Шөнө унтах гэж л гэртээ харьдаг гээд хэлчихвэл буруудахгүй. Миний ар тал найдвартай учраас би санаа зовохгүйгээр ажилдаа зүрх сэтгэлээ зориулж яваа хэрэг. Миний бахархал бол миний сургууль. Намтар маань ганцхан өгүүлбэрт багтдаг. Би энэ сургуулийг төгссөн, эндээ багшилсан, эрдмийн зэрэг цолоо ч эндээ л хамгаалсан. Тэнхимийн эрхлэгчийг нь хийсэн, бүрэлдэхүүн сургуулийн захирлаар нь ч ажилласан. Эдүгээ их сургуулийнх нь захирлаар ажиллаж байна. Тиймээс энэ сургууль дээр юу нь болж, юу нь болохгүй давуу тал нь аудитын албатай. Бид нэг шийдвэр гаргалаа. Санхүүжилтэд нь аудит хийж, алдаа оноо хийгээд хууль дүрэмд зохицож байгаа эсэхийг нягталж шалгадаг. Түүнээс би мундагтаа биш. Манай баг нэг зүг рүү харж чаддаг учраас энэ бүх бүтээн байгуулалтын ард гарч чадсан гэж би бардам хэлнэ.

**-Таны яг доктор хамгаалсан сэдэв тань юу вэ. Удирдах ажил хийхээр эрдмийн ажил гээгддэг тал байдаг?**

-Би хүний их эмч, дархлаа судлаач. Магистр, докторын зэргээ ч “Тодорхой өвчний үед хүний дархлаа тогтолцоо яаж удаагаа хэвлүүлэх гэж байна. Би 2003 онд анхныхаа сурах бичгийг гаргасан. Үзсэн чинь түмэн алдаа. Тэгээд бүгдийг нь хураан авч байлаа. Дараа жил нь багш нартайгаа хамтарч хоёр дахь хэвлэлээ гаргасан. Одоо засч сайжруулсан долоо дахь хувилбар нь. Их гоё ном болж байгаа. Номын зохиогч нь долоон хүний автортай. Харамсалтай нь таны хэлснээр сүүлийн гурван жил судалгаа, шинжилгээний ажлаасаа хөндийрч, аж ахуйн ажилтан болжээ. Шавь нартаа зарцуулах цаг маань багасч байгаад дотроо гэмшингүй л явдаг юм.

**-Ер нь Монголд элэгний** **маяг гэж хэллээ. Гэтэл та өөрөө...?**

-Хамгийн гол нь би идэвхтэй амарч чаддаг. Амралтын өдрийг өөртөө зориулдаг. Хүн долоон цаг унтахад л болно. Харин нойроо хасч болохгүй, эртхэн сэрж байх ёстой. Миний тухайд хариуцлага хүлээж байгаа юм чинь хүлээсэн шиг хүлээх ёстой. Ямар нэгэн хувийн эрх ашиг гаргахгүйгээр ажиллах ёстой. Учир нь бид, манай баг сургуулийнхаа энэ цаг үеийн түүхийг бичилцэж байгаа байхгүй юу. Тиймээс алдаа гаргахгүй төлөө хичээн ажиллаж байна даа.


“ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ



Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо толол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ТАНЫ БЯЦХАН ЧРС ЗӨВ МОНГОЛ ХЧН БОЛНО

**Холбоо барих утас: 99094864**

# ЦАГ ҮЕ

УИХ-ЫН ГИШҮҮН ТОЙРОГТОО...













**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

С.Чинзориг гишүүний хувьд нийгмийн хамгааллын салбарт мэргэшсэн түшээ гэдгээрээ бусдаас ялгардаг. Тийм ч учраас сонгуулийн үеэр малчид, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийг боловсронгуй болгох амлалтыг өгсөн бөгөөд амлалтаа эхнээс нь биелүүлж өнгөрсөн хоёр сарын хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай гэсэн хоёр ч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Засгийн газраар дэмжүүлсэн. Эдгээр хуулийн төсөлд малчдын тэтгэвэрт гарах насыг таван жилээр наашлуулж, ээжүүдийн хүүхдээ асарсан хугацааны шимтгэлийг төрөөс хариуцах, тэдний төрүүлж өсгөсөн хүүхдийн тоогоор улсад ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцох, тогтмол орлогогүй малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломж олгох зэрэг заалт орсон нь олны талархал хүлээж буй юм.

Хүүхдийн гарын ая даахгүй, жил бүр шинээр хэвлэж байна шүү дээ.

-Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 100 хувь төрөөс даадгийг болиулж талыг нь эцэг, эхээс нь гаргуулна гэдэг хөдөө сумынханд хүндрэлтэй болно. Сард 33 мянган төгрөг төлөөд хүүхдээ явуулах боломжтой айл хэд билээ. Тэгээд ч нэг айлаас нэг л хүүхэд явдаггүйг бодолцох хэрэгтэй байх.

-Оюутны 70 мянгыг зогсоож, сургалтын төлбөрийн зээл олгодог болно гэсэн нь хэзээнээс хэрэгжих вэ.

-2012 оноос хэрэгжиж байгаа "Зөв монгол хүүхэд" хөтөлбөрт хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх сайхан заалт бий. Гэвч орон нутагт хүүхдийн тал бүрийн авьяасыг хөгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл дутмаг.

-Орон нутагт ажилладаг багш нарт таван жил тутамд олгодог нэмэгдлийг сургуулийн үйлчилгээний туслах ажилтнуудад олгож болохгүй юу.

## Сант сум

-Хэдийгээр бид УИХ-ын үйл ажиллагааны талаар телевизээр мэдээлэл авч байгаа ч яг ингэж биечлэн ирж тайлбарлан

-Малыг, махыг гадагшаа гаргах боломж бололцоог нээж, малыг эрүүлжүүлэхэд төрөөс анхаарах.

-Оффшор дансны тухай их шуугисан. Үнэхээр тийм их хэмжээний мөнгө гадагш нь гаргаад нуучихсан юм бол түүнийг нь яаж ийгээд буцаагаад аваад ирж болдоггүй юм уу.

-Хөдөөд эмч, эмнэлгийн ажилтны үнэлэмжийг дээшлүүлмээр байна.

-Хөдөө аж ахуйн бирж гэж байгуулсан ч малчидтай биш ченжүүдтэй ажиллаад байгаагаас малын гаралтай түүхий эдийн үнэ өсч чадахгүй, малчдын амьдрал сайжрахгүй байна.

-Малчид одоо нэгдэж нийлж байж хөгжихгүй бол ганц ганцаараа урагшлахаа болилоо.

## Хайрхандулаан сум

-Хаа хаанаа улстөржилтийг багасгамаар байна. Намын нэрээр чадваргүй хүмүүсийг албан тушаалд томилох нь төрд ч, намд ч гай болж байна.

-Улс орны амьдрал ард түмнээс болж муу байгаа юм биш. Төрийн зөв, цэгцтэй бодлого үгүйгээс өнөөдрийн хүндрэлд тулсан. Тиймээс бид тогтолцоогоо өөрчилж

# С.ЧИНЗОРИГ

...УИХ-ын гишүүний үүрэг хууль тогтоох ч иргэд өөрсдийнхөө сонгосон түшээд тулгамдсан асуудлаа дуулгаж, хэрэгтэй зүйлдээ дэмжлэг авахыг хүсдэг. Гишүүд ч нутаг орны хөгжилд тус дэм болохоор хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эрэлд гардаг нь нууц биш. С.Чинзориг гишүүн ч тойрогтоо гар хоосон очоогүй...

Өвөрхангайнхан өөрсдийг нь төрд төлөөлж буй гишүүнийхээ яриаг тун ч анхааралтай сонсохын хамт тэдэнд асуух зүйл ч арвин, төр засгийн бодлого шийдвэрт тусгуулах санал олныг хэлсэн. Улс орны хөгжлийнгарцбарагдаждуусдаг байгалийн баялаг биш харин олон жилийн уламжлалтай мал аж ахуй гэдгийг анхаарч, амьсгалаас бусдыг нь ашиглаж болдог малын үнэ цэнийг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулахад малчдад төрөөс дэмжлэг үзүүлэхийг хүсч байв. Мөн улс орныг эдийн засгийн хүндрэлд тулгаж, ард түмний амьдралыг дордуулсан буруу шийдвэрийн эздэд хариуцлага тооцохыг олон хүн шаардсан.

Иргэдийн С.Чинзориг гишүүнд тавьсан асуулт, хүсэлт, төрд хүргэх санал бодлыг сум сумаар нь тоймлон хүргэж байна.

## Есөнзүйл сум

-Сум дундын эмнэлэг гэсэн статустай ч Эрүүл мэндийн төвийн барилга хуучирсан, засвар хийх шаардлагатай. Засварын санхүүжилтийг хүсч "Өвсний үндэс" хөтөлбөрт хандсан ч бүтээгүй. Байр савны багтаамжгүйгээс нарийн мэргэжлийн эмч нар нэг өрөөнд олноороо сууж үзлэгээ хийдэг. Эмчилгээний тоног төхөөрөмж ирдэг ч тавих газар байхгүй. Тухайлбал, бид одоо хүртэл шүдний кабинетаа ажиллуулж чадахгүй байна. Эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмж стандартын бус. Өвчтөнүүдийнхээ хоолыг хятад цахилгаан тогоонд хийж байна шүү дээ. Тиймээс манай эмнэлгийн хуучин байрны засварын асуудлыг шийдэж өгөөч.

-2014 онд шинэ Соёлын төвтэй болсон ч одоо болтол шаардлагатайтоногтөхөөрөмж, тайзны хөшиг байхгүй.

-Сургуулийн заалны шал мөөгөнцөртөж, тэнд сургалт хүмүүжлийн ажил явуулах боломжгүй болсон.

## Өлзийт сум

-Боловсролын салбарт хийж байгаа хөрөнгө оруулалтыг үр дүнтэй болгоход илүү анхаармаар байна. Наад зах нь сурах бичгийн чанарыг сайжруулж, насыг нь урт байхаар хийж болохгүй юу.

таниулах нь хамаагүй үр дүнтэй юм байна.

-Манай сумын эмнэлэг ирэх сард магадлан итгэмжлэлд ороход эмийн хөргүүр хэрэгтэй байна.

-Бэлчээр ашигласны төлбөр хаашаа ордог, юунд зарцуулагддаг болохыг тодорхой болгох шаардлагатай. Уурхайн хөлд нэрвэгдэж бэлчээр, ундны ус хомсдолд орж буй нь малчдад хүнд тусч байна.

## Баянгол сум

-Тэтгэврийн насыг эрэгтэй, эмэгтэй ялгаагүй 60 болгоно гэдэг үнэн үү. Эмэгтэйчүүд гэж их ярих юм. Гэтэл эрчүүдэд төрөөс тавих анхаарал халамж үгүйлэгдэж байна шүү дээ.

-Төр барьж, бодлого гаргаж буй хүмүүст хэлэхэд улс орны хөгжил, ард түмний аж амьдралыг сайжруулахын тулд зөв гэж үзсэн шийдвэрийнхээ төлөө тууштай зогсдог, зоригтой байх хэрэгтэй. Татвар нэмэх ёстой гэж үзсэн бол нэмэх л хэрэгтэй. Түүнээс хүмүүст таалагдахын тулд ажиллаж болохгүй.

шинэчлэх тал дээр дорвитой алхам хийх цаг болжээ.

-Өвөрхангайд махны үйлдвэртэй болно гэсэн яасан бэ.

## Нарийнтээл сум

-Тэтгэвэр нэмэх арга байна уу.

-Банкны тэтгэврийн зээлийн хүүг бууруулах тал дээр анхаарч өгөөч.

-Малын элдэв халдварт өвчин даамжирлаа. Энэ нь махаа гадагш нь гаргах боломжийг хааж байна.

-Сургуульд хүүхдүүдээ сургахын тулд айл гэр хоёр тасарч амьдрахад хүрч байна. Эмэгтэйчүүд хүүхдээ дагаад суман дээр, эрчүүд малаа дагаад хөдөө үлддэг болсон.

-Уурхайн ажилчдыг хүнд хортой нөхцөлөөр тооцож эрт тэтгэвэрт гардаг байсныг болиулсан нь орон нутгийн уурхайд ажиллаж буй хүмүүсийн хувьд хэтэрхий хатуу байна.

## Баруунбаян-Улаан сум

-Хамтын тэтгэврийн хуулийг яагаад хүчингүй болгов.

-Хүүхдийн мөнгийг олгох шалгуур гэж буй өрхийн амьжиргааны төвшинг яаж тогтоогоод байгааг ойлгохгүй байна.

-Бидний төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэл хаашаа орж байна вэ. НДС хоосорсон гэдэг үнэн үү.

-МАН-аас амласан "Насны хишиг"-ийг хэзээнээс өгөх боломжтой вэ.

## Богд сум

-Өнгөрсөн Засгийн газрын үлдээсэн өрийн хариуцлагыг тооцох талаар бодож байгаа юм бий юу.

-Цалингийн том зөрүүг арилгамаар байна. Сарын 4-5 саяын цалинтай шүүгчийн ажлын ачаалал 400-500 мянгын цалинтай сумын эмчийнхээс их гэж үү.

-Өнөөгийн Засгийн газар мөнгө олох боломж, арга зам хайж байна уу.

-Тавантолгойн 1072 хувьцааны мөнгөө яаж авах вэ.

-Өрийн дээд хязгаар 88 хувьд хүрсэн гэсэн. Танай нам ирэх дөрвөн жилд энэ хязгаарыг нэмэх үү.

ЦАГ ҮЕ



# ГИШҮҮН ХИЙСЭН АЖЛАА ТАЙЛАГНАЖ, ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨСНӨӨ ТАНИЛЦУУЛАВ

-Малчдын банкны зээлийн мөнгөөр амьдарч, чанаргүй боловсон хүчин бэлтгэн ажилгүйчүүдийн тоог нэмж байгаа хувийн дээд сургуулиудын тоог хумиж болохгүй юу.

## Гучин Ус сум

-Манай улс өнгөрсөн дөрвөн жилд эдийн засгаас гадна улс төрийн гүнзгий хямралд орсон. Төсөвт орлогоосоо давсан зарлага төлөвлөөд байдгийн учрыг ойлгохгүй юм.

-Эрдэнэтийн 49 хувийг яг хэн авсан юм бэ. Болж бүтэж байсан зүйлсээ өмч хувьчлал нэрээр нураах устгаад байгааг эргэж харах хэрэгтэй байна. Улс өөрийн гэсэн өмчгүй боллоо.

-Улсын төсвийн хөрөнгөөр барилга байшинд засвар хийх боломж байна уу. Сум инженерийн шугам сүлжээгүй учраас сургуулийн орчин хүүхдэд ээлтэй ариун цэврийн орчныг бүрдүүлж чадахгүй байна.

-Сургуулийн дотуур байрыг ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан. Өмнөх дөрвөн жилд бид хүсэлт гаргаад шийдүүлж чадаагүй. Анхаарах боломж байна уу.

-Цагурагшлуулж,хойшлуулах нь хүний биеийн био хэмнэлтэй зөрчилддөг. Үүнийг зогсоож болохгүй юу.

-Малынхаа тоог үнэн гаргаж баймаар байна. Банкнаас зээл авахын тулд малаа нэмж худлаа тоолуулдаг. Тиймээс бодитой болгохын тулд зөв тоолж, татварыг нь яс авч байх хэрэгтэй.

## Төгрөг сум

-Сумаа хөгжүүлмээр байна. Үүний тулд дулааны хямд, байгальд хоргүй эх үүсвэрийг нэвтрүүлэхэд анхаарах нь нэн тэргүүний асуудал.

-Төр засаг мал эмнэлгийн үйлчилгээ, малын даатгалыг өөртөө авах ёстой.

-Малын тоо толгой хоёр дахин өслөө гэж буй ч мал маллададаг малчны тоо хоёр дахин цөөрсөн. Залуу малчдыг бэлтгэх, дэмжих тал дээр төрийн бодлого зайлшгүй шаардлагатай байна.

-Төрийн албаны илүү орон тоог цомхотгож, цомхотголд орсон хүмүүсээ материаллаг үйлдвэрлэлийн салбарт ажиллах боломжоор хангах нь төр засгийн үүрэг байх ёстой.

Хэдийгээр УИХ-ын гишүүний үүрэг хууль тогтоох ч иргэд өөрсдийнхөө сонгосон түшээд тулгамдсан асуудлаа дуулгаж, хэрэгтэй зүйлдээ дэмжлэг авахыг хүсдэг. Гишүүд ч нутаг орны хөгжилд тус дэм болохоор хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эрэлд гардаг нь нууц биш. С.Чинзориг гишүүн ч тойрогтоо гар хоосон очоогүй. Сум бүрийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгт хэрэгцээтэй зүйлийг нь судалж чамгүй хөөцөлдсөний үр дүнд иж бүрэн компьютер, хөлдөөгч, гал тогооны тоног төхөөрөмж тэр ч бүү хэл Богд суманд нэн шаардлагатай байсан түргэн тусламжийн машины асуудлыг ч шийдэж өгсөн. Мөн түүний сонгогдсон тойргийн бүх сумын Эрүүл мэндийн төвд Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар 1,0 сая ам.долларын эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмж нийлүүлэхээр болсон баяртай мэдээг дуулгасан.



Түүнийг тойрогтоо ажиллах үеэр Баян-Өндөр, Баруунбаян-Улаан сумын цэцэрлэгийн шинэ өргөтгөл нээлтээ хийж таарсан. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр барьсан шинэ цэцэрлэг тус бүртээ 50 хүүхэд бүхий хоёр ангийг нээжээ. С.Чинзориг гишүүн бяцхан хүүхдүүдийн боловсролд зориулан сэтгэлийн хандив өргөв. Мөн Туркийн Анкарад болох ДАШТ-д эх орноо төлөөлөхөөр явах гэж буй бяцхан тамирчны замын зардалд хувиасаа 500 мянган төгрөг хандивлалаа.

Өмнө сонгосон гишүүн нь сонгууль дөхөхөөр л бараагаа харуулдгаас анхдугаар чуулганы дараа шуудхан ирж хийсэн ажлаа тайлагнаж, хийхээр төлөвлөснөө танилцуулж, төр засгийн бодлого шийдвэрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч байгаагүйг иргэд онцолж, С.Чинзориг гишүүнд талархал илэрхийлж амжилт хүслээ.




NO STRESS

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +3
Шөнө -6

Нөгөөдөр
Өдөр +2
Шөнө -7

## Өдрийн зурхай

**Аргын тооллын:**
*2016 оны 10-р сарын 06, Пүрэв гараг*

**Билгийн тооллын:**
*Намрын адаг шар нохой сарын шинийн 5. Долоон улаан мэнгэтэй Цагаагчин тахиа өдөр. Бархасбадь гараг*

**Наран ургах/шингэх:**
*07:06 / 18:32*

**Үс засуулбал:**
*Эд, мал арвижна.*



Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, гарагийг тахих, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиаболой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

СОНИРХУУЛАХАД

# "Амьд барби" Монголд ирлээ



Б.ДАВАА

Дэлхийд чансаагаараа дээгүүрт бичигддэг "Face of beauty international" олон улсын миссийн тэмцээнд оролцохоор Эстони, Словак, Замби зэрэг 60 гаруйорныгоо бүсгүйчүүд манай оронд хүрэлцэн ирээд байгаа билээ. Тэгвэл уг тэмцээний нэгэн сонирхолтой шүүгч нь "амьд барби" хочит Украины мисс, Валерия Лукьянова юм. Тэрбээр өчигдөр өглөө 06.00 цагт Монголд хүрэлцэн ирсэн бөгөөд түүнийг ёслол төгөлдөр угтан авчээ. Ингээд уншигчиддаа түүний талаархи сонирхолтой мэдээллээс хүргэе. Валерия Валерьевна Лукьянова 1985 оны наймдугаар сарын 23-нд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан Молдав улсын Тирасполд мэндэлжээ. Түүний ээж Ирина цэргийн байгууллагад ажилладаг бол аав нь барилгачин аж. Гэхдээ сонирхолтой нь эцэг, эх нь ч гэсэн барбитай төстэй царайтай гэнэ. Тэрбээр хүүхэд байхаасаа л охидын хайрыг татдаг барби цуглуулдаг нэгэн байсан бөгөөд харин эдүгээ өөрөө тэрхүү хүүхэлдэйтэй тун ижилхэн харагддаг болсон юм. Валерия загвар өмсөгч, дуучин, бас жүжигчин. Гэвч түүний эзэмшсэн мэргэжил нь энэ биш. Бүсгүй Украины "Одесс барилга архитектур"-ын академийг архитектурын чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн гэнэ шүү. Тэрбээр контакт линз болон нүүр будалтын хүчээр барби мэт харагддаг. Гэхдээ түүний будалтыг мэргэжлийн нүүр будагч хариуцдаг гэнэ. Түүнийг 2007 оноос олны хараанд өртөж эхэлсэн гэхэд хилсдэхгүй. 2007 онд тэрбээр "Miss Diamond Crown of the World" гоо бүсгүйчүүдийн тэмцээнд оролцож, тэргүүн титмийн эзэн болж байлаа. Ямар нэг шалгуургүй, гоо сайхны мэс засал хийлгэсэн бүсгүй ч оролцож болдог гэдгээрээ онцлог тус тэмцээнд орон орны 300 гаруй гоо бүсгүйчүүд оролцсон байдаг. 300 гаруй бүсгүйчүүд дундаас өөрийн авьяас чадвар гоо үзэсгэлэнгээрээ эрхгүй ялгарч, тэргүүн титмийг хүртсэн бүсгүйн нэр алдар алга урвуулах төдийд л олны анхаарлыг татаж эхэллээ. Оросын хэвлэл мэдээллийн хэрэгслээр түүний эротик зураг, ярилцлагууд цацагдах болсон бөгөөд тэрбээр өөрөө ч видео, зургаа вэб хуудастаа нийтлэх болсон байдаг. Улмаар түүний төрх байдал нь дэлхий нийтийн анхаарлыг татаж, "Амьд барби" гэх нэрээр олонд танигдаж эхэлсэн түүхтэй. Ингэж л архетиктурч мэргэжилтэй бүсгүй "Хүн барби", "бодит амьдрал дээрх барби", "амьд барби" гэх зэргээр цоллуулах болсон байна. 2013 онд бүсгүй өөрийн амьдралаас сэдэвлэсэн "Space Barbie" гэх бүтээлийг гаргаж байжээ. Олон нийт түүнийг мэс засал хийлгэж өнөөгийн галбираа олсон гэж үздэг. Гэхдээ бүсгүй хиймэл хөхтэй гэдгээ хүлээн зөвшөөрдөг ч, өөр мэс засал хийлгээгүй хэмээдэг.

Мөн бэлхүүсээ нарийсгах зорилгоор хавиргаа авахуулсан гэх мэдээллийг ч үгүйсгэдэг билээ.

2014 оны гурван сарын байдлаар гэхэд түүний фэйсбүүк шүтэн бишрэгчдийн тоо аль хэдийнэ нэг саяд тулж, твиттерт дагагчид нь 10 мянга болсон байлаа.

Түүний урын санд 100 гаруй дуу бий. Мөн "The Phase" гэх кинонд тоглосон бөгөөд уг кино долоон орны хэлээр гарчээ. Тэрбээр мөн хөгжмийн зохиолч, дуурийн дуучин бөгөөд Валерия аль хэдийнэ хоёр ч цомгоо гаргачихсан сүйхээтэй нэгэн. Түүний цомгийн нэр нь "2013", "Sun in the Eyes". Мөн "Astral Travel Amatue" гэх ном бичсэн удаатай. Хувийн амьдралынх нь тухай сонирхуулахад, мэдээж тэр гэрлэсэн. Түүний амьдралын ханиар сонгогдсон азтай эр бол багынх нь найз Украины бизнесмэн Дмитрий Шкрабов юм. Мөн Валерия цагаан хоолтон төдийгүй, шингэн хоолны дэглэм барьдаг ажээ. Валерия Лукьянова 16 насандаа Украины Одесс руу шилжин, тэндээ 2014 оныг хүртэл суурьшжээ. Харин зүүн Украины байдал хурцдах үед бүсгүй нөхрийнхөө хамт Москвад ирж тэндээ амьдрах болсон гэнэ.

ДУУЛГАХ СОНИН

## Загвар өмсөгч Э.Энхболд реалити шоу хийнэ

Н.ЗАЯА

Америкийн загвар өмсөгч Tyra Banks-ын хөтөлдөг "America's Next Top Model" реалити шоу Монголын үзэгчдийн үзэх дуртай нэвтрүүлгийн нэг болж чадсан билээ. Тэгвэл арваннэгдүгээр сард тус шоуг Монголд хийхээр болжээ. Энэхүү шоуны албан ёсны эрхийг Боловсрол суваг телевизийн хамт олон авсан байна.

Дэлхийн 170 гаруй оронд албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлдэг уг реалити шоу нь Монголын телевизийн салбар дахь гурав дахь томоохон хэмжээний шоу юм.

Мөн "America's Next Top Model" реалити шоу нэвтрүүлгийн продюссер монголд хүрэлцэн ирж, зөвлөгөө өгч ажиллах аж.

Одоогоор уг шоуны оролцогчдын бүртгэл эхлээгүй байгаа бөгөөд моделиор ажиллах хүсэлтэй бүхий л залууст энэ боломж нээлттэй гэнэ. "Mongolia`s Next Top Model" реалити шоуны оролцогчоор зургаан эрэгтэй, найман эмэгтэй нийт 14 моделийг шалгаруулж авах төлөвлөгөөтэй байгаа аж.

Харин "Mongolia`s Next Top Model" шоуны шүүгчид одоогоор тодорхойгүй байгаа гэнэ. Дашрамд сонирхуулахад, тус шоуны продюссерээр ажиллаж буй загвар өмсөгч Э.Энхболд ажиллаж байгаа ажээ.

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Munkhtuya Gantulga

Ээж "Movie box" суваг дээр нөгөө л үздэг солонгос сериалаа үзэж байлаа. Би ч хажууд нь гэмгүй л сууж байв. Гэтэл үзэж байсан кинон дээр нь гэрлэх гэж байгаа охиноо эцэг нь "Миний муу хөгшин охин" гэж хэлээд уйлалдаад л байлаа. Тэгсэн ээж нулимсаа арчаад л над руу огцом эргэж харснаа "Ингэж хэлүүлтлээ битгий миний хажууд удаарай" гэдэг юм даа. Би өмнөөс нь би яасан юм гэсэн царай гаргачихлаа. Уг нь би чинь дөнгөж л хорьж болдоггүй насан дээрээ байгаа хүн шүү дээ. Ха ха ха


